

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНООС 2013 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ЗАВСАРЛАГААНЫ ХУГАЦААНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2014.03.28.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо 2013 оны намрын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд Ухаалаг төр рүү шилжих Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд 2014 онд хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

нэг. Зохион байгуулсан хурал, уулзалт, ярилцлага

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааныг 2014 оны 3 дугаар сарын 26-ны өдөр хуралдуулж, “Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахаар бэлтгэсэн болно.

Улсын Их Хурлын 2013 оны намрын чуулганы завсарлагааны хугацаанд Төрийн байгуулалтын байнгын хорооноос хэд хэдэн уулзалт, ярилцлагыг зохион байгууллаа. Үүнд:

-Улс төрийн намын тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хуралд суудалгүй намуудын дарга, ерөнхий нарийн бичгийн дарга нарыг оролцуулсан “Дугуй ширээний ярилцлага”-ыг 2014 оны 2 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж, хуулийн төсөлтэй холбоотой тэдгээрийн саналыг авлаа.

-2014 оны 3 дугаар сарын 18, 21-ний өдрүүдэд Улс төрийн намын тухай хуулийн төслийг боловсруулах ажлын дэд хэсэг хуралдаж, төсөлд тусгуулахаар холбогдох газар, иргэдээс ирүүлсэн саналыг хэлэлцэн, төслийн хоёр дахь хувилбарыг боловсруулав.

-Үндсэн хуулийн цэцийн гишүүд, Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн хамтарсан ажил хэргийн уулзалтыг 2014 оны 3 дугаар сарын 17-ны өдөр зохион байгууллаа.

-Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран Улсын Их Хурлын Тамгын газраас хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Хангайн бүсийн аймгуудын нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хамтарсан онол практикийн бага хурлыг 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Орхон аймагт зохион байгуулав. “Ухаалаг төр рүү шилжих санаачлагын хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох нь” сэдэвт энэхүү бага хуралд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей, Улсын Их Хурлын гишүүн М.Батчимэг, Су.Батболд, Ерөнхийлөгчийн Хүний эрх, хуулийн бодлогын зөвлөх Ч.Өнөрбаяр, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ажилтнууд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монголын нутгийн удирдлагын холбоо, Монголын баг, сумдын үндэсний холбооны төлөөлөл, Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Хурлын байгууллагын ажлын албаны

ажилтнууд зэрэг 100 гаруй хүн оролцож, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх зүйн орчныг сайжруулах, ажлын үр өгөөж, арга хэлбэрийг өөрчлөн шинэчлэх чиглэлээр илтгэлүүд тавьж, зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар болон нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр саналаа нэгтгэн гаргав.

“Цахим Монгол” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хийж байгаа ажлын талаар Мэдээллийн технологи, шуудан, холбооны газрын даргын мэдээллийг сонсохоор бэлтгэлийг хангаж байна.

2014 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Байнгын хорооноос 2013 оны намрын чуулганы хугацаанд хийсэн ажлын талаар болон цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар хэвлэлийн бага хурал хийж, сэтгүүлчдийн сонирхсон асуултуудад Улсын Их Хурлын гишүүд хариулт өглөө.

Бусад ажлын талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 хэсгийг үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар 2013 онд хийсэн ажлын тайланг Улсын Их Хурлын 2014 оны хаврын ээлжит чуулганы эхэнд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхтэй холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2014 оны 3 дугаар сард багтаан тайлангаа гарган ирүүлэх тухай албан бичиг явуулав. Мөн Төрийн албаны зөвлөлд 2013 оны үйл ажиллагааныхаа тайланг хуульд заасан хугацаанд ирүүлэх талаар албан бичиг явуулсан.

Сайн засаглал ба ухаалаг засаглалын зарчим, дэлхий нийтийн хандлага, бусад орнуудын туршлага, Засгийн газрын чиг үүрэг, бүтцийг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын судалгаа хийлгэх захиалгыг холбогдох байгууллагад өгөөд байна.

Байнгын хорооны ажлын албанаас Засгийн газрын тухай болон Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар танилцуулга бэлтгэж, Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн ажилтнуудад танилцуулав.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ АЖЛЫН АЛБА